



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн өмчийн их сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 306 дугаар тогтоолын 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөрийн давхардлыг арилгаж, төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор доор дурдсан төрийн өмчийн зарим мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг тус тус өөрчлөн зохион байгуулсугай:

2.1.Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвтэй нийлүүлж Орхон аймаг дахь Политехник коллеж болгон;

2.2.Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж, Дархан-Өргөө политехник коллеж, Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийг нийлүүлж Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллеж болгон;

2.3.Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг тус аймаг дахь Политехник коллежид нэгтгэн.”

2.Мөн тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН БРӨНХИЙ САЙД

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ЭНХ-АМГАЛАН